# ХҮНС ҮЙЛДВЭРЛЭЛ, БАРИЛГА УГСРАЛТ, ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ "ХӨВСГӨЛ ХҮНС"ХУВЬЦААТ КОМПАНИИН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 дүгээр сарын 29-ий өдөр №2 Мөрөн хот

Компанийн бизнес үйл ажиллагааны тайлан батлах тухай

Хүнс үйлдвэрлэл, барилга угсралт, худалдаа үйлчилгээний "Хөвсгөл Хүнс" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2026 оны ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн Тогтоох нь:

1. Компанийн гүйцэтгэх удирдлагаас оруулсан 2025 оны үйл ажиллагааны талаарх тайланг баталсугай.

2. Компанийн 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсугай.

3. 2026 оны ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА Л.ДАШЦЭРЭН

**ХҮНС ҮЙЛДВЭРЛЭЛ, БАРИЛГА УГСРАЛТ, ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ "ХӨВСГӨЛ ХҮНС"ХК-ИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2025 онд "Ховсгол Хүнс"ХК нь Талх гурилан боов, жимс жимсгэний өтгөрүүлсэн шүүс варианъ , ургамлын цай, сүүн ааруул, нөөшилсөн бүтээгдэхүүн, архи үйлдвэрлэлийн гэсэн үндсэн гол нэрийн хүнсний бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн хөдөлмөрчдийн хэрэгцээнд нийлүүлсэн байна. Үүнд:

- Талх – 72560 кг
- Нарийн боов-167105 кг
- Варень – 6541 кг
- Чихэр – 2210 кг
- Жимсний шүүс-2861 л
- Загас -9160 кг
- Архи – 14343 л
- Торт – 1125 кг
- Цэвэр ус - 5890л
- Тасалсан гурил 280кг

"Ховсгол Хүнс"ХК нь 48 ажилчин албан хаагчтай 2024 онд ажилчдын тоогоо бууруулаагүй хадгалж шинээр гурван орон тоог нэмэгдүүлж ажилласан байна,

2025 онд "Хөвсгөл Хүнс"ХК нь Талх нарийн боовны үйлдвэрлэлийн технологийн шинэчлэлт хийх /орц жорын сонголт /норм, түүхий эд материалын хүнсний нэмэлт, чанарын сайжруулалтыг иж бүрнээр хэрэгжүүлэх ажлыг мөн нарийн боовны сав баглаа боодлыг шинэчлэн сайжруулж бүтээгдэхүүний нэр төрлийг олшируулж шинээр торт нандин бүтээгдэхүүн , тасалсан гурилын үйлдвэрлэлийг өргөжүүлэн ажиллуулж байна.

Нөөшилсөн бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх нөөшилсөн бүтээгдэхүүний цехийн ашиглалтын түвшинг нэмэгдүүлж /мах нөөшлөх, ногоо нөөшлөх, хатаах, санлах, утах/ гэх мэт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, сав баглаа боодлыг асуудлыг шийдвэрлэн ажиллаж байна.

Сүү цагаан идээ, байгалын баялаг ашиглах экологийн цэвэр хүнс үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийн технологийн арга ажиллагаар боловсронгуй болгох зорилгын хүрээнд, уламжлалт сүү цагаан идээний цехийн үйл ажиллагааг мөн дарс хийх талаар судлан ажиллаж байна.

**"Ховсгол Хүнс"ХК**

**ХҮНС ҮЙЛДВЭРЛЭЛ, БАРИЛГА УГСРАЛТ, ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ "ХӨВСГӨЛ ХҮНС"ХК-ИЙН 2026 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

"Хөвсгөл Хүнс"ХКомпани 2026 онд дараах төлөвлөгөө, зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Үйлдвэрлэлийн чанарын хяналтыг сайжруулах, дотоод хяналтын тогтолцоог нарийн зохион байгуулалтад оруулж, тусгай журманд оруулах.
2. Бүтээгдэхүүний сав баглаа боодлыг шинэчлэх сайжруулах шинэ өнгө төрхийг бий болгож, багцын бүтээгдэхүүн гаргах.
3. Талх нарийн боовны үйлдвэрлэлийн технологийн шинэчлэлт хийх /орц жорын сонголт /норм, түүхий эд материалын хүнсний нэмэлт, чанарын сайжруулалтыг иж бүрнээр хэрэгжүүлнэ.
4. Нөөшилсөн бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх нөөшилсөн бүтээгдэхүүний цехийн ашиглалтын түвшинг нэмэгдүүлэх /мах нөөшлөх, ногоо нөөшлөх, хатаах, савлах, утах/ гэх мэт.
5. Сүү цагаан идээ, байгалын баялаг ашиглах экологийн цэвэр хүнс үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийн технологийн арга ажиллагааг бүлэнсронгүй болгох арга хэмжээ авна.
6. Шинэ нэр торлийн бүтээгдэхүүнийг зах зээлд таниулах бүх талын арга хэмжээг шат дараатай зохион байгуулах
7. Талх нарийн боовны цехийн үйлдвэрлэл борлуулалтыг Хөвсгөл аймгийн зах зээлд шинэ шатанд гаргах
8. Компанийн гол нэрийн брэнд бүтээгдэхүүнүүдийг Монгол улсын зах зээлд гаргах
9. Компанийн нэрийн барааны өөрийн дэлгүүр шинээр 1-2 салбартай болох
10. Түүхий эд хадгалах хоргүүр шинээр барих

**ХҮНС ҮЙЛДВЭРЛЭЛ, БАРИЛГА УГСРАЛТ, ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ "ХӨВСГӨЛ ХҮНС" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр    № 1    Мөрөн

Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах тухай

Хүнс үйлдвэрлэл, барилга угсралт, худалдаа үйлчилгээний "Хөвсгөл Хүнс" ХК - ийн хувьцаа эзэмшигчдийн 2026 оны ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь :

1. Компанийн санхүүгийн тайлан, хараат бус аудитын байгууллагаар хийлгэсэн аудитын тайлан, дүгнэлтийг зөвшөөрсүгэй.

ТУЗ-ЫН ДАРГА    Л.ДАШЦЭРЭН

**ХҮНС ҮЙЛДВЭРЛЭЛ, БАРИЛГА УГСРАЛТ, ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ "ХӨВСГӨЛ ХҮНС" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2026 оны 04 дүгээр сарын 29 өдөр №3 Мөрөн хот

Хянан шалгах зөвлөлийн тайланг батлах тухай

Хүнс үйлдвэрлэл, барилга угсралт, худалдаа үйлчилгээний "Хөвсгөл Хүнс" ХК -ийн хувьцаа эзэмшигчдийн 2026 оны ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн Тогтоох нь :

1. Компанийн 2025 оны үйл ажиллагаанд Хянан шалгах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг зөвшөөрсүгэй.

ТУЗ-ЫН ДАРГА Л.ДАШЦЭРЭН

# ХҮНС ҮЙЛДВЭРЛЭЛ, БАРИЛГА УГСРАЛТ, ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ "ХӨВСГӨЛ ХҮНС"ХК-НИЙ ХЯНАН ШАЛГАХ ЗӨВЛӨЛИЙН ТАЙЛАН ДҮГНЭЛТ

Тус компани нь 2025 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусгавар болгон санхүүгийн байдлын тайлан, дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан тэнцлээ олон улсын стандарт болон мөрдөж байгаа хууль тогтоомжийн дагуу бэлтгэн толилуулж, хараат бус аудитын итгэмжлэгдсэн байгууллага "Ихэр Мөрөн Аудит" ХХК-иар хянуулан баталгаажуулсан байна. Компаний удирдлага, санхүүгийн үйл ажиллагаа нь борлуулалтын орлогыг зохих түвшинд нэмэгдүүлэх, өртөг зардлаа хямдруулах, үйл ажиллагааны зардлаа зохих түвшинд байлгах, өр төлбөрөө бууруулах зэрэгт үйл ажиллагаагаа чиглүүлж ажилласан байна.

Хүнс үйлдвэрлэл, барилга угсралт, худалдаа үйлчилгээний "Хөвсгөл Хүнс" ХК-ийн 2025 оны үйл ажиллагааг үзэж танилцахын зэрэгцээ жилийн эцсийн санхүүгийн тайлан, бусад холбогдох дотоод тайлан мэдээнд үндэслэн тайлант жилийн үйл ажиллагааны үр дүн, санхүүгийн байдалд үнэлэлт өгвөл:

Нэг. Үйл ажиллагааны үр дүнгийн талаар

Компанийн 2024, 2025 оны орлогын тайлангийн үзүүлэлтээс зэрэгцүүлэн үзвэл:
/сая.төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх жил | Тайлант жил | Өсөлт /бууралт/ |
|---|---|---|---|
| Борлуулалт | 2281.6 | 2984.4 | 702.8 |
| Борлуулалтын хөнгөлөлт | | | - |
| Цэвэр борлуулалт | 2281.6 | 2984.4 | 702.8 |
| Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | 1816.6 | 2365.2 | 370.9 |
| Нийт ашиг | 465.1 | 619.2 | 154.1 |
| Үйл ажиллагааны зардал | 286.7 | 353.0 | 66.3 |
| Үйл ажиллагааны ашиг /алдагдал/ | 178.4 | 266.7 | 88.3 |
| Үндсэн бус үйл ажиллагааны ашиг /алдагдал/ | | | |
| Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/ | 178.4 | 266.7 | 88.3 |
| Орлогын татварын зардал | 17.8 | 26.7 | 8.9 |
| Цэвэр ашиг, алдагдал | 160.5 | 240.0 | 79.5 |

Үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтүүд болох борлуулалтын орлого 2025 онд өмнөх онтой харьцуулахад 702.8 сая төгрөгийн буюу 23.6 %-ийн өсөлттэй байна. Хүнс үйлдвэрлэл, барилга угсралт, үйлдвэрлэл үйлчилгээний "Хөвсгөл Хүнс"ХК нь 2025 оны
Үйл ажиллагааны зардлыг авч үзвэл 34,6 сая буюу 18.78 %-иар үйл ажиллагааны зардал өмнөх оноос өсөлттэй тухайн онд цалин хөлс нэмэгдсэн,мөн бусад зардалууд нэмэгдсэн байна. 2024 онд үндсэн үйл ажиллагаа цэвэр ашиг 160.5 сая төгрөгийн ашигтай байсан бол тайлант онд 240.0 сая төгрөгийн ашигтай гэсэн үзүүлэлттэй байна. Дээрх бүх

нөлөөллийн улмаас 2025 онд өмнөх оноос цэвэр ашгийн хэмжээ 79.5 сая төгрөг өсөлттэй гарсан байна.

Хоёр. Санхүүгийн байдлын талаар

Компаний 2024, 2025 оны хөрөнгө, эх үүсвэрийн тэнцлийн үзүүлэлтээс зэрэгцүүлэн үзвэл:

/сая.төгрөгөөр/

| Хөрөнгө, өр төлбөрийн үзүүлэлтүүд | 2024 он | 2025 он | Өсөлт/ бууралт |
|---|---|---|---|
| Эргэлтийн хөрөнгө | 728.5 | 899.7 | 171.2 |
| Эргэлтийн бус хөрөнгө | 280.7 | 282.0 | 1.3 |
| Нийт хөрөнгийн дүн | 1009.2 | 1181.6 | 172.4 |
| Богино хугацаат өр төлбөр | 473.2 | 407.0 | (66.2) |
| Урт хугацаат өр төлбөр | | | 0 |
| Эзэмшигчдийн өмчийн дүн | 536.0 | 774.5 | 238.5 |
| Өр төлбөр, эзэмшигчийн өмчийн дүн | 1009.2 | 1181.6 | 172.4 |

2025 онд эргэлтийн хөрөнгийн дүн 171.2 сая төгрөгийн өсөлттэй байгаа нь тухайн онд Сав баглаа,бараа материалын үлдэгдэл буурч дансны авлага нэмэгдсэн байна. Тайлант оны хувьд нийт хөрөнгийн 76.14% нь эргэлтийн хөрөнгө, үлдэж буй 23.86% нь эргэлтийн бус хөрөнгө байна.

**ХҮНС ҮЙЛДВЭРЛЭЛ, БАРИЛГА УГСРАЛТ, ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ "ХӨВСГӨЛ ХҮНС"ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2026 оны 04 сарын 29 өдөр № 4 Мөрөн хот

ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын 2026 оны зардлын төсөв батлах тухай

Хүнс үйлдвэрлэл, барилга угсралт, худалдаа үйлчилгээний "Хөвсгөл Хүнс"ХК -ийн хувьцаа эзэмшигчдийн 2026 оны ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн Тогтоох нь :

1. Компанийн ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын 2026 оны зардлын төсвийг хавсралтаар нийт 24000000 төгрөгөөр баталсугай.

ТУЗ-ЫН ДАРГА Л.ДАШЦЭРЭН

*Хүнс үйлдвэрлэл, барилга угсралт, худалдаа үйлчилгээний "Хөвсгөл Хүнс"ХК-ийн 2026 оны 04 сарын29-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 4 –р тогтоолоор*

*батлав.*

# ТУЗ БОЛОН ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН ЗАРДЛЫН ТӨСӨВ

| | **Зардлын төрөл** | **Хэмжих нэгж** | **2026 он** |
|---|---|---|---|
| 1 | ТУЗ-н даргын цалин | Төгрөг | 5,000,000 |
| 2 | Гүйцэтгэх захирлын цалин | Төгрөг | 18,000,000 |
| 3 | ТУЗ-ын хурлын зардал | Төгрөг | 1000000 |
| | Нийт | Төгрөг | 24,000,000 |

**"Хөвсгөл Хүнс" Хувьцаат Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын**
**тоологын комиссын**
**ТОГТООЛ**

2026 оны 04 дүгээр сарын 29 Дугаар 01 Мөрөн

Монгол Улсын компанийн тухай хууль, "Хөвсгөл Хүнс" хувьцаат компанийн дүрмийн дагуу компанийн ТУЗ-ын бүрэлдэхүүнийг сонгоход хуралд орлцсон хувьцаа эзэмшигчдийн санал хурасан дүнг үндэслэн ТОГТООХ нь:

| № | Санал хураасан асуудал | Нийт хувьцааны тоо | Санал хураалтад оролцсон хувьцааны тоо | Зөвшөөрсөн | Татгалзсан | Зөвшөөрсөн хувь |
|---|---|---|---|---|---|---|
| 1.Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр сонгох.Үүнд: | | | | | | |
| | Ц.Мөнх-эрдэнэ | 263820 | 185882 | 185882 | | 100% |
| | Л.Тэгшбаяр | 263820 | 185882 | 185882 | | 100% |
| | Л.Тунгалаг | 263820 | 185882 | 185882 | | 100% |
| | С.Нэргүй | 263820 | 185882 | 185882 | | 100% |
| | Л.Дашцэрэн | 263820 | 185882 | 185882 | | 100% |
| | С.Отгонбаатар | 263820 | 185882 | 185882 | | 100% |
| **Хараат бус** | | | | | | |
| | Д.Ган-Очир | 263820 | 185882 | 185882 | | 100% |
| | Ц.Намхай | 263820 | 185882 | 185882 | | 100% |
| | Ж.Сайнжаргал | 263820 | 185882 | 185882 | | 100% |

Комиссын дарга: Ж.Алтангэрэл

Гишүүд: Б.Дашзэвэг

Т.Бямбажаргал

**"Хөвсгөл Хүнс"ХКомпанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийн бүртгэл**

2026.04.29

| Д/д | БЦК-ийн нэр | Овог нэр | Регистрийн дугаар | Хувьцааны | | Хурлын ирц |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | тоо | Хувьцаа | |
| 1 | Хөвсгөл бирж | Л.Дулам | РУ33042803 | 83 | 0.031 | 0.031 |
| 2 | Хөвсгөл бирж | Б.Зинаахүү | РЮ42030110 | 225 | 0.085 | 0.085 |
| 3 | Хөвсгөл бирж | З.Нарантуяа | ИЮ70032404 | 223 | 0.084 | 0.084 |
| 4 | Хөвсгөл бирж | З.Сарантуяа | РЮ74071701 | 218 | 0.082 | 0.082 |
| 5 | Хөвсгөл бирж | З.Алтантуяа | РЮ67051002 | 212 | 0.080 | 0.080 |
| 6 | Хөвсгөл бирж | З.Алтансух | РЮ77041318 | 218 | 0.082 | 0.082 |
| 7 | Дархан брокер ҮЦК ХХК | Л.Дашцэрэн | РУ71010301 | 270 | 0.102 | 0.102 |
| 8 | Дархан брокер ҮЦК ХХК | Хөвсгөл Геологи ХК | 2034441 | 161238 | 61.1 | 61.1 |
| 9 | Ард секюритиз ҮЦК ХХК | Л.Төмөрбаатар | РЭ67052115 | 22744 | 8.6 | 8.6 |
| 10 | Гүүдсек ҮЦК ХХК | Ш.Амарсайхан | РЭ68121703 | 244 | 0.092 | 0.092 |
| 11 | Гүүдсек ҮЦК ХХК | Д.Энхтайван | РЭ63080215 | 200 | 0.075 | 0.075 |
| 12 | Гүүдсек ҮЦК ХХК | Д.Гэрэлчулуун | РЮ53081014 | 3 | 0.001 | 0.001 |
| 13 | Голомт капитал ХХК | Э.Долзодмаа | РЮ60022302 | 3 | 0.001 | 0.001 |
| **Дүн** | | | | **185882** | **70.46** | **70.46** |